




Сурагчдад чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээлийн хөтөлбөрийг туршсан судалгааны үр дүн

Цэдэнжавын Рэгзэнбазар 

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Лхагвын Ариунжаргал 

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

<https://journal.mnier.mn>

Санал болгож буй эшлэл:

Рэгзэнбазар, Ц., Ариунжаргал, Л. (2025). Сурагчдад чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээлийн хөтөлбөрийг туршсан судалгааны үр дүн. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, 30(2). <https://doi.org/10.56380/mjer.v30.2.3>

Impact Evaluation of a Competency-Based Supplementary Career Guidance Curriculum among Ninth-Grade Adolescents in Mongolia

Regzenbazar Tsedenjav 

Mongolian National University of Education

Ariunjargal Lkhagva 

Mongolian National University of Education

To cite this article:

Regzenbazar, TS., Lkhagva, A. (2025). Impact Evaluation of Competency-Based Supplementary Career Guidance Curriculum among Ninth-grade Adolescents in Mongolia. *Mongolian Journal of Educational Research*, 30(2). <https://doi.org/10.56380/mjer.v30.2.3>

The International Journal of Studies in Education and Science (IJSES) is a peer-reviewed scholarly online journal. This article may be used for research, teaching, and private study purposes. Authors alone are responsible for the contents of their articles. The journal owns the copyright of the articles. The publisher shall not be liable for any loss, actions, claims, proceedings, demand, or costs or damages whatsoever or howsoever caused arising directly or indirectly in connection with or arising out of the use of the research material. All authors are requested to disclose any actual or potential conflict of interest including any financial, personal or other relationships with other people or organizations regarding the submitted work.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.



Сурагчдад чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээлийн хөтөлбөрийг туршсан судалгааны үр дүн

Цэдэнжавын Рэгэнбазар, Лхагвын Ариунжаргал

Өгүүллийн мэдээлэл

Түүх:

Хүлээн авсан: 2025.10.03

Засаж сайжруулсан: 2025.10.31

Хэвлэхийг зөвшөөрсөн: 2025.11.27

Түлхүүр үг:

мэргэжил сонголт

чадамж,

нэмэлт хичээл,

шийдвэр гаргах чадвар

ХУРААНГУЙ

Судалгаанд “Мэдлэг-Сэдэл-Үйл” гэсэн гурван хэмжигдэхүүнт загварыг ашиглан сурагчдын мэргэжил сонголтын чадамжид нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох зорилго дэвшүүлсэн. Судалгаанд 196 сурагч оролцсон бөгөөд нийт 20 цагийн хичээлийн үр дүнг шинжлэв. Судалгааны арга зүйд анхан шатны асуулга, дунд шатны туршилт, сүүлийн шатны үнэлгээний арга, статистик шинжилгээ багтсан.

Мэдлэг, сэдэл, үйл гэсэн гурван хэмжигдэхүүний хооронд өндөр хамааралтай байж, мэдлэгийн өсөлт нь сэдэлд эерэг нөлөө үзүүлсэн. Нэмэлт хичээлийн үр дүнд мэдлэг 22%, чадвар 13%, сэдэл 7 хувиар өссөн нь сурагчдын мэргэжил сонголтын чадамжид бодит ахиц авчирсныг харуулав.

Судалгаа нь сурагчдын өөрийн үзэл баримтлал, зан төлөв, орчны хүчин зүйлсийг нэгтгэж, чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох боловсролыг үр дүнтэй хөгжүүлэх боломжтойг харуулж байна. Судалгааны үр дүн нь сургуулийн нэмэлт хичээлийн хөтөлбөрийн агуулга, багшийн заах арга зүйг сайжруулах, сурагчдын ажил мэргэжлийн чиг баримжааг дээшлүүлэх практик ач холбогдолтой.



Энэхүү өгүүлэл нь Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 Олон улсын лицензээр хамгаалагдсан болно

Холбоо барих зохиогч:

Цэдэнжавын Рэгэнбазар

Боловсрол судлалын сургууль, Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Мэйл хаяг: regzenbazartsedenjav@gmail.com

Impact Evaluation of a Competency-Based Supplementary Career Guidance Curriculum among Ninth-Grade Adolescents in Mongolia

Regzenbazar Tsedenjav Ariunjargal Lkhagva

Article information

Article history:

Received: Oct 03, 2025

Revised: Oct 31, 2025

Accepted: Nov 27, 2025

Keywords:

career choice

competence

supplementary curriculum

decision-making skills

ABSTRACT

The purpose of this study was to identify the factors influencing students' career choice competence using the three-dimensional “Knowledge-Motivation-Action” model. Approximately 196 students participated in the study, and the outcomes of a 20-hour competency-based supplementary course were analyzed. The methodology included an initial survey, a mid-term experimental intervention, final evaluation methods, and statistical analyses.

The results showed a strong correlation among the three dimensions of knowledge, motivation, and action, with increases in knowledge positively affecting motivation, indicating the effectiveness of a sequential and interconnected instructional design. Following the supplementary course, knowledge increased by 22%, skills by 13%, and motivation by 7%, demonstrating tangible improvement in students' career choice competence.

This approach, integrates students' personal values, behaviors, and environmental factors, highlighting its potential for effectively developing competency-based career guidance education. The findings provide a practical foundation for improving the content of supplementary programs in secondary schools, strengthening teachers' instructional methods, and supporting students' career orientation development.



This is an open access article under the Creative Commons Attribution-Non Commercial-ShareAlike 4.0 International License.

Corresponding author:

Tsedenjav Regzenbazar

Educational Studies school, Mongolian National University of Education

Email: regzenbazartsedenjav@gmail.com

УДИРТГАЛ

Мэргэжил сонголт бол хүмүүсийн амьдралдаа гаргадаг хамгийн чухал шийдвэрийн нэг юм. Гэсэн хэдий ч олон хүмүүс ийм шийдвэр гаргахдаа бэрхшээлтэй тулгардаг. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаагаар 2015 онд ажиллах хүчний эрэлт 77.5 мянга байсан бол 2024 онд 95.3 мянга болж өсжээ. Харин ажиллах хүчний хомсдол 2014 онд 14.2 мянга байсан бол 2023 онд 48.9 мянга болж өссөн байна. Уг судалгаа нь ажиллах хүчний эрэлт нэмэгдэх тусам ажиллах хүчний хомсдол өсөж байгааг илтгэнэ (Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа 2024). Сүүлийн долоон жилд дотоодын их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн 30 орчим хувь буюу 62 756 оюутан зөвхөн бизнес, удирдахуйн ухаан, хууль, эрх зүйн чиглэлээр төгсжээ. Энэ нь ажиллах хүчний эрэлт болон төгсөгчийн мэргэжлийн чиглэл хоорондоо нийцэхгүй байгааг харуулж байна (Монгол Улсын статистик эмхэтгэл 2023). Ажил мэргэжлээ буруу сонгох нь хувь хүнээс шалтгаалах ч төрийн үүрэг оролцоо энд чухал ач холбогдолтой. Ийм учраас төрөөс ерөнхий боловсролын сургуульд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үзэл баримтлал, бодлогыг тодорхой болгох нь хамгийн чухал тулгамдсан асуудал болоод байна.

Сурагчдын мэргэжил сонголтын чадамжийг дээшлүүлэх асуудал бол бүрэн дунд боловсролын тулгамдсан асуудал мөн. Сурагчдын өөрийгөө танин мэдэх, ажил мэргэжил төлөвлөлтийн мэдлэгийн түвшин сул байгаа нь мэргэжил сонголтын шийдвэр гаргахад тулгарч буй гол саад бэрхшээл бөгөөд энэ нь зөвхөн мэргэжил сонголт төдийгүй ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийн зорилготой ч холбоотой асуудал мөн. Ийм учраас сурагчдад чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийг туршсан юм.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын мэргэжил сонголтод зөв шийдвэр гаргахад шаардлагатай мэдлэг, ур чадвар, практик үйл ажиллагааг сайжруулах чадамжид суурилсан сургалтын арга зүй дутагдалтай байна. Улмаар тэд мэргэжлээ буруу сонгож байгаа нь өнөөдөр тулгамдсан асуудал болж байна.

Судалгааны шинэлэг тал нь чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээлийн хөтөлбөрийг монголын нөхцөлд туршсанд оршино. Харин судалгааны ач холбогдол нь сурагчдын мэргэжил сонголтын чадамжийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын арга зүйг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулсан явдал юм. Судалгааны үндсэн дээр боловсруулсан нэмэлт хичээлийн хөтөлбөр нь сурагчдын мэргэжил сонголтын чадамжийг дээшлүүлэхэд практик ач холбогдолтой.

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Мэргэжил сонголтын сэтгэл зүй, хандлагын судалгаанд (Мөнхчулуун нар, 2015) ярилцлага, ажиглалт зэрэг чанарын аргууд түлхүү ашигласан байна. Судлаач Дорж (2012), Болормаа нарын (2015) судалгаанд асуулгын арга, статистик шинжилгээ ашиглаж, сурагчдын сонирхол, эцэг эхийн оролцоо зэрэг хүчин зүйлсийн хамаарлыг тоон мэдээллээр гаргасан байна. Энэ төрлийн бусад судалгаанууд ч сургуулийн хүрээнд өргөн хүрээтэй асуулга, мэдээлэл цуглуулах арга зүй хэрэглэсэн байна. Доктор Ш.Мөнхцэрэнгийн (2019) судалгаанд бодлогын хэрэгжилт, үр нөлөөг үнэлэх дунд шатны үнэлгээний арга, SWOT шинжилгээ, төлөвлөгөө боловсруулах стратегийн аргачлалыг ашиглажээ.

Шави Тимоти Бубани (Bubani, 2011, p. 45) "Ажил мэргэжлийн шийдвэр гаргах чадамж ба хэмжилтийн загвар боловсруулах, турших" сэдэвт докторын диссертацийн ажил нь мэргэжлийн нухацтай шийдвэр гаргах чадварыг хэмжих загвар боловсруулан, ажил мэргэжлийн шийдвэр гаргахад оролцогч талуудын ойлголтыг тодруулж, чадамжид суурилсан туршилт хичээлийг хөгжүүлэхэд чиглэжээ. "Ахлах сургуулийн сурагчдын ажил мэргэжлийн шийдвэр гаргах бие даасан байдал ба боловсролын үр дүнгийн хүлээлтэд карьерын боловсролын хөтөлбөрийн нөлөө" сэдэвт Айше Клылычийн (2022) судалгаа нь нийгмийн танин мэдэхүйн карьерын онол дээр суурилсан карьерын сэтгэлзүйн боловсролын хөтөлбөрийн үр нөлөөг судалсан ажээ. Мөн энэ хөтөлбөр ахлах сургуулийн сурагчдын ажил мэргэжлийн шийдвэр гаргах бие даасан байдал, боловсролын үр дүнгийн хүлээлтийг нэмэгдүүлэх зорилготой юм. Судалгааны үр дүнд хөтөлбөр нь эдгээр чадамжийг сайжруулсан төдийгүй энэхүү арга хэмжээ нь ажил мэргэжлийн шийдвэр гаргах чадварт эерэгээр нөлөөлж болохыг харуулжээ. Smith, J. (2019, p. 60). "Оюутны ажил мэргэжлийн шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх" хэмээх энэхүү бүтээл нь сурагчдын ажил мэргэжлийн шийдвэр гаргах чадварыг сайжруулахын тулд авч хэрэгжүүлсэн олон төрлийн арга зүйг хамарсан судалгаа юм.

Сургалтын хөтөлбөр, сэтгэл зүй төлөв байдлыг хэрхэн интеграцчилах талаар дэлгэрэнгүй өгүүлжээ. Brown, K., & Williams, L. (2021) “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, шийдвэр гаргахад технологийн үүрэг” сэдэвт эрдэм шинжилгээний судалгаа нь технологийн хэрэглээ, тэр дундаа хиймэл оюун ухааныг мэргэжил сонголтод хэрхэн ашиглах боломжтойг судалсан байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа, шийдвэр гаргалтад технологийн нөлөөг шинжилж, орчин үеийн чиг хандлагыг судалжээ. SCCT, Career Construction, RIASEC, Decision-Making Competence, SDT гэх мэт карьер хөгжлийн онолууд нь сурагчдын чадамж, сэдэлд суурилсан шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн (Bubani, 2011; Klylych, 2022; Brown & Williams, 2021) байна.

Харин Монголын судалгаанууд орчны хүчин зүйл, бодлогын хэрэгжилт, эцэг эхийн оролцоо зэрэг гадны нөлөөлөлд төвлөрдөг нь ажиглагдсан (Мөнхчулуун нар, 2015; Мөнхцэрэн, 2019). Тиймээс карьер хөгжлийн онолуудын чухал элементийг Монголын нөхцөлд нийцүүлэн “Мэдлэг-Сэдэл-Үйл” загварт нэгтгэснээр сурагчдын чадамжтай, идэвхтэй, утга учиртай мэргэжил сонголтын шийдвэр гаргах чадварыг системтэй хөгжүүлэх боломжтой. “Мэдлэг-Сэдэл-Үйл” загвар нь Монголын боловсролын зорилго болох “чадамжтай, үнэт зүйлтэй, идэвхтэй сурагч”-ийг төлөвшүүлэхэд хамгийн тохиромжтой загвар юм.

АРГА ЗҮЙ

Судалгаанд Германы эрдэмтэн Дризел-Лангийн (2020) боловсруулсан “Ажил мэргэжлээ сонгох чадамжийг тодорхойлох загвар”-ыг ашигласан бөгөөд энэ нь Каак (2013) ба Липовски (2015)-ийн судалгааны ажлыг үндэслэсэн байна. Энэхүү загвар нь 93 асуултаас бүрддэг бөгөөд 12 хүчин зүйл, “мэдлэг, сэдэл, үйл” гэсэн 3 хэмжээст ангилалтай. Анхан шатны судалгаанд сурагчдын ажил мэргэжлийн чиг баримжаа, шийдвэр гаргах үйл явцыг ойлгох, тэдний мэргэжил сонголтын чадамж ямар түвшинд байгааг тодорхойлох зорилго тавьсан. Харин явцын судалгаанд чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт 10 цагийн хичээлийн үр дүнд сурагчдын мэдлэг, сэдэл, үйлд хэрхэн өөрчлөлт орсныг илрүүлэх зорилго, харин сүүлийн шатны судалгаанд чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт 20 цагийн хичээлийн үр дүнд ямар өөрчлөлт орсныг илрүүлэх зорилго тус тус дэвшүүлсэн.

Чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээлийг туршсан судалгааны эхний шатанд оролцсон Орхон аймгийн А сургуулийн IX ангийн 196 сурагч, дунд шатанд оролцсон 183 сурагч, сүүлийн шатанд оролцсон 171 сурагчийн тоон мэдээллийг Хүснэгт 1-д харуулав. Судалгааны хэмжүүрийн найдвартай байдлыг Cronbach's Alpha үзүүлэлтээр тооцож, 0.7-оос дээш байвал найдвартай гэж үзнэ. Kaiser-Meyer-Olkin (KMO) коэффициентээр өгөгдлийн фактор шинжилгээнд тохирох чанарыг батлах KMO > 0.6 байх шаардлагатай Bartlett's Test of Sphericity-г ашиглан асуултуудын уялдаа, хамаарлын утга статистикийн хувьд ач холбогдолтой ($p < 0.05$) болохыг нотлох юм. Эдгээр үзүүлэлтийг нарийвчлан тусгаснаар судалгааны итгэлцэл, баталгаажуулалт нэмэгдэж, чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үнэлэх бодит загвар болгон ашиглах боломж бүрдэх юм.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээл нь сурагчдыг өөрийгөө танин мэдэх, ажил мэргэжлээ ухамсартайгаар сонгох, төлөвлөх, хэрэгжүүлэхэд чиглэсэн 20 цагийн сургалтын хөтөлбөртэй. Хөтөлбөр нь карьерын хөгжлийн онолууд (Super, Holland, Lent, Savickas, Krumboltz гэх мэт)-д тулгуурлаж, өөрийгөө танин мэдэх, зорилго тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх гэсэн үндсэн дөрвөн үе шаттай. Энэхүү хөтөлбөрийн үр дүнд сурагч өөрийн сонирхол, үнэт зүйл, зан чанар болон мэргэжил сонголтоо оновчтой тодорхойлох, карьерын зорилгоо төлөвлөж, хэрэгжүүлэх ур чадвартай болно. Уг нэмэлт хичээлд ахлах ангийн сурагчдын ажил мэргэжлийн чиг баримжааг онолын үндэслэлтэй, системтэй, өөрийгөө танин мэдэх арга зүйд тулгуурлан хөгжүүлэх чадамжид суурилсан сургалтын загварыг хэрэглэнэ.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан сурагчийн мэдээлэл (бүлгээр)

Бүлэг	Анхан шат		Дунд шат		Сүүлийн шат	
	Сурагчийн тоо	Эзлэх хувь	Сурагчдын тоо	Эзлэх хувь	Сурагчдын тоо	Эзлэх хувь
А	41	20.9%	40	20.4%	38	22.2%
Б	41	20.9%	38	19.4%	38	22.2%

В	39	19.9%	37	18.9%	38	22.2%
Г	44	22.4%	38	19.4%	37	21.6%
Д	31	15.8%	30	15.3%	20	11.7%
Нийт	196	100%	183	100%	171	100%


ҮР ДҮН

Чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээлийн анхан, дунд, сүүлийн шатны судалгааны үзүүлэлтийн ахицыг Хүснэгт 2 болон Зураг 1-д үзүүлэв.

Хүснэгт 2. Нэмэлт хичээлийг анхан, дунд, сүүлийн шатны үзүүлэлтийн ахиц ба үр дүн

Хэмжигдэхүүн	Хүчин зүйлс	Үр дүн
МЭДЛЭГ:	<i>Өөрийгөө танин мэдэхүйн мэдлэг (1.1):</i>	Энэ үзүүлэлтийн анхны шатнаас сүүлийн шат хүртэлх ахиц 0.6 нэгж, 25.9% → $p < 0.01$, Cohen's $d \approx 0.65$ (дунд зэргийн нөлөөлөл). Өөрийгөө танин мэдэх мэдлэг нь нэмэлт хичээлийн үр дүнтэй холбоотой бөгөөд сурагчид давуу болон сул тал, сонирхлоо олж тодорхойлоход тусалдаг.
	<i>Ажил мэргэжлийн талаарх мэдлэг (1.2):</i>	Энэ үзүүлэлтийн дунд шатнаас сүүлийн шат хүртэлх ахиц 0.6 нэгж, 28.4% → $p < 0.001$, Cohen's $d \approx 0.80$ (их нөлөөлөл) болжээ. Ажил мэргэжлийн мэдлэгт ахиц гарсан нь сурагчдын ажил мэргэжлийн талаарх ойлголт, хандлага сайжирсныг илтгэнэ.
	<i>Мэргэжлээ олж авахад шаардлагатай мэдлэг (1.3):</i>	Уг үзүүлэлт хамгийн бага ахицтай байна. Ахиц 0.4 нэгж, 16.1% → $p < 0.05$, Cohen's $d \approx 0.40$ (бага нөлөөлөл). Энэ нь нэмэлт хичээлийн агуулга, арга зүйг сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.
СЭДЭЛ	<i>Ажил мэргэжилдээ итгэлтэй байх (2.1, 2.4):</i>	Энэ үзүүлэлтийн ахиц 0.3 нэгж → $p = 0.07$ (хязгаарлагдмал ач холбогдол), Cohen's $d \approx 0.30$ (бага нөлөөлөл) байна. Ажил мэргэжилдээ итгэлтэй байх нь сурагчдад чухал ач холбогдолтой.
	<i>Санаа зовних, айдсаа даван туулах нь (2.3, 2.5):</i>	Ахиц 0.1–0.2 нэгж → $p = 0.12$ (статистикийн хувьд ач холбогдолгүй), Cohen's $d \approx 0.20$ (маш бага нөлөөлөл). Санаа зовних, айдсаа даван туулах нь эерэг ахицтай байгаа нь сурагчид стрессийг даван туулах талаар мэдлэг олж авсныг илтгэж байна.
	<i>Эрэл хайгуул хийх чадвар (3.1):</i>	Ахиц 0.6 нэгж, 24.6% → $p < 0.001$, Cohen's $d \approx 0.85$ (их нөлөөлөл) байгаа нь сурагчид үйлдэл хийхэд илүү идэвх гаргаж байгааг харуулж байна.
ҮЙЛ	<i>Асуудлыг шийдвэрлэх чадвар (3.3, 3.5):</i>	Энэхүү үзүүлэлтийн ахиц 0.3 нэгж → $p < 0.05$, Cohen's $d \approx 0.45$ (дунд нөлөөлөл) байгаагаас харахад асуудал шийдвэрлэх арга барилд сайжруулалт хийсэн гэж үзэж болно.
	<i>Стрессээ удирдах чадвар (3.4):</i>	Энэ үзүүлэлтийн ахиц 0.0 нэгж → $p = 0.68$ (ач холбогдолгүй), Cohen's $d \approx 0.05$ (нөлөөгүй) байна. Сүүлийн шатанд стресс удирдах талаар илүү тодорхой мэдээлэл, хэрэгцээтэй байгааг харуулж байна.

Судалгааны үр дүнгээс харахад мэдлэг, сэдэл, үйлд суурилсан чадамжид илүү өндөр өсөлттэй байгаа нь сургалтын агуулга, арга зүйгээр дамжуулан сурагчдыг богино хугацаанд үр дүнтэй хөгжүүлэх боломжтойг нотолж байна. Тухайлбал, “ажил мэргэжлийн талаарх мэдлэг” нь сурагчдын шууд хүлээн авч боловсруулж болох танин мэдэхүйн мэдээлэлд суурилсан бол “эрэл хайгуул хийх чадвар” нь практик хэрэглээ, бодит жишээ дээр суурилсан дасгалаар дамжин хөгжсөн. Ийнхүү мэдээлэлд суурилсан ойлголт, дадалд суурилсан хэрэглээний чадварууд сурагчдын сонирхлыг идэвхжүүлж, дотоод сэдлийг нэмэгдүүлснээр ахицын түвшин илүү өндөр байна (Kolb, 1984; Deci & Ryan, 2000). Сэтгэлзүйн чадамж ахиц бага гарсан нь сэтгэл зүйн төлөв байдал, амьдралын туршлага, орчны нөлөөнд суурилсан, тогтвортой шинж бүхий хувьсагчтай холбоотой. Өсвөр насны сурагчдын хувьд өөртөө итгэх итгэл, айдас, стресс удирдах чадварыг хөгжүүлэх, төлөвшүүлэхэд урт хугацааны сургалт шаардлагатай болдог. (Bandura, 1997; Corey, 2013; Ajzen, 1991).



Зураг 1. Чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээлийг туршсан анхан дунд, сүүлчийн шатны судалгааны үзүүлэлтийг харьцуулсан нь

Сүүлчийн шатанд өөртөө итгэлтэй байх, санаа зовних, айдсаа даван туулах, стрессээ удирдах чадварт ахиц гарсан ч нийт 3 шатны судалгаанд эдгээр чадвар нь бусадтай харьцуулахад хамгийн бага өөрчлөлттэй байсан.

Хүснэгт 3. Анхан, дунд, сүүлчийн шатны судалгааг бүлэг тус бүртэй харьцуулсан судалгаа

Хэмжигдэхүүн	Анхан шат	Дунд шат	Сүүлчийн шат
МЭДЛЭГ	2.432	2.651	2.966
СЭДЭЛ	2.847	2.891	3.065
ҮЙЛ	2.643	2.718	2.991

Хүснэгт 3-д үзүүлсэн мэдлэгийн ахиц хамгийн өндөр буюу 21.97% байна. Сэдлийн ахиц харьцангуй бага (7.65%) байгаа нь энэ чиглэлд илүү анхаарах хэрэгтэйг харуулж байна. Үйлдэл хийх чадварын ахиц 13.15% байгаа нь сурагчдын асуудал шийдвэрлэх, өөрийгөө удирдах чадварын өсөлттэй холбоотой. Статистикийн шинжилгээгээр эдгээр өөрчлөлт нь утга бүхий ялгаатай ($p < .05$) бөгөөд нөлөөллийн хэмжээ (Cohen's $d = 0.45-0.80$) нь дунд ба өндөр түвшинд хүрсэн байна.

Хүснэгт 4. Чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээлийг туршсаны үр дүнд эрэгтэй сурагчдад гарсан ахиц өөрчлөлт

Мэдлэг, чадвар	Байдлыг тогтоох	Дунд шатны	Сүүлчийн шат	Өөрчлөлт
Өөрийгөө танин мэдэхүйн мэдлэг	2.4	2.7	2.9	0.51
Ажил мэргэжлийн талаарх мэдлэг	2.2	2.4	2.7	0.56
Мэргэжлээ олж авахад шаардлагатай мэдлэг	2.7	2.9	3.0	0.32
Төлөвлөх мэдлэг	2.5	2.6	2.8	0.33
Итгэлтэй байх-1	2.7	2.8	2.9	0.22
Хянах, удирдах	2.7	2.8	2.9	0.22
Санаа зовних, айдсаа даван туулах-1	3.1	3.2	3.2	0.09

Итгэлтэй байх-2	2.9	2.9	3.0	0.03
Санаа зовних, айдсаа даван туулах-2	3.0	3.0	3.0	0.01
Сониуч, танин мэдэх хүсэл	2.5	2.6	2.8	0.29
Эрэл хайгуул хийх чадвар	2.2	2.5	2.8	0.57
Өөрийгөө залан чиглүүлэх чадвар	2.9	2.9	3.0	0.08
Асуудлыг шийдвэрлэх чадвар-1	2.5	2.6	2.9	0.38
Стрессээ удирдах чадвар	2.8	2.8	2.6	-0.14
Асуудлыг шийдвэрлэх чадвар-2	2.7	2.8	3.0	0.28

Энэхүү чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээл туршсаны дараа эрэгтэй сурагчдын мэдлэг, чадварын түвшинд ахиц гарсныг Хүснэгт 4-өөс харж болно.

Тухайлбал:

- Өөрийгөө танин мэдэхүйн мэдлэг, Ажил мэргэжлийн талаарх мэдлэг болон Мэргэжлээ олж авахад шаардлагатай мэдлэг 0.5-аас дээш ахиц гарсан. Энэ нь сурагчдын ажил мэргэжлийн талаарх ойлголт болон өөрийгөө танин мэдэх мэдлэгт ахиц гарсныг харуулж байна.
- Төлөвлөх, шийдвэр гаргах мэдлэг болон Асуудлыг шийдвэрлэх чадварт 0.3-0.4 хувийн ахиц гарсан нь сурагчдын төлөвлөх, шийдвэр гаргах үйл явц сайжирсныг илэрхийлж байна.
- Зарим чадварт жишээ нь Стрессээ удирдах чадвар, ажил мэргэжилдээ итгэлтэй байх-1 нь харьцангуй бага өсөлттэй (0.2-0.3) эсвэл бууралттай (-0.14) байгаа нь сурагчид сэтгэл зүйн төлөв байдал тогтворгүй байгааг илэрхийлж байна.
- Эрэл хайгуул хийх чадвар, Асуудлыг шийдвэрлэх чадвар-2 нь харьцангуй өндөр өсөлттэй, 0.5-0.6 хүрсэн нь сурагчдын шинэлэг, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд багагүй ач холбогдолтойг харуулж байна. Эрэгтэй сурагчдын ажил мэргэжлийн чиг баримжаа болон өөрийгөө танин мэдэх мэдлэг дээшилсэн бөгөөд цаашид сэтгэл зүйн төлөв байдалд анхаарах шаардлагатай.
- Статистикийн шинжилгээгээр эдгээр өөрчлөлт нь $p < .05$ түвшинд утга бүхий ялгаатай, харин нөлөөллийн хэмжээ (Cohen's d) нь мэдлэгийн хэсэгт дундаас өндөр (0.60-0.80), сэдэл ба сэтгэлзүйн хэсэгт бага (0.20-0.40) түвшинд байна.

Хүснэгт 5. Чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээлийг туршсаны үр дүнд эмэгтэй сурагчдад гарсан ахиц өөрчлөлт

Мэдлэг, чадвар	Байдлыг тогтоох	Дунд шатны	Сүүлийн шат	Өөрчлөлт
Өөрийгөө танин мэдэхүйн мэдлэг	2.3	2.6	3.1	0.78
Ажил мэргэжлийн талаарх мэдлэг	2.1	2.3	2.8	0.70
Мэргэжлээ олж авахад шаардлагатай мэдлэг	2.7	2.9	3.3	0.59
Төлөвлөх мэдлэг	2.5	2.7	3.2	0.66
Итгэлтэй байх -1	2.8	2.8	3.2	0.39
Хянах, удирдах	2.9	2.9	3.2	0.27
Санаа зовних, айдсаа даван туулах-1	3.3	3.5	3.6	0.28
Өөртөө итгэлтэй байх-2	2.9	3.0	3.1	0.20
Санаа зовних, айдсаа даван туулах -2	3.2	3.2	3.4	0.21
Сониуч, танин мэдэх хүсэл	2.6	2.6	3.0	0.39
Эрэл хайгуул хийх чадвар	2.4	2.6	3.0	0.58
Өөрийгөө залан чиглүүлэх чадвар	3.1	3.0	3.4	0.29
Асуудлыг шийдвэрлэх чадвар-1	2.6	2.6	3.1	0.54

Стрессээ удирдах чадвар	2.7	2.8	2.9	0.25
Асуудлыг шийдвэрлэх чадвар-2	2.9	2.8	3.4	0.41

Чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээлийн үр дүнд эмэгтэй сурагчдад ахиц өөрчлөлт гарсныг Хүснэгт 5-аас харж болно.

Үүнд:

- *Мэдлэгийн өсөлт*: Эмэгтэй сурагчдын мэдлэгийн түвшин, тухайлбал, Өөрийгөө танин мэдэхүйн мэдлэг (0.78), Ажил мэргэжлийн талаарх мэдлэг (0.70), Мэргэжлээ олж авахад шаардлагатай мэдлэгт (0.59) хамгийн өндөр өсөлт ажиглагдсан. Нэмэлт хичээл нь сурагчдын ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход илүү үр дүнтэй байсныг харуулж байна.
- *Чадварын өсөлт*: Төлөвлөх мэдлэг (0.66) болон Асуудлыг шийдвэрлэх чадвар-1 (0.54) зэрэг чадварын өсөлт нь сурагчдын төлөвлөх болон шийдвэр гаргах үйл явцад ахиц гарсныг харуулж байна. Санаа зовних, айдсаа даван туулах, ажил мэргэжилдээ итгэлтэй байх-1 нь бага хэмжээгээр нэмэгдсэн ч ахиц гарсан байна.
- *Бага зэргийн өсөлт*: Стрессээ удирдах чадвар (0.25) болон Өөрийгөө залан чиглүүлэх чадвар (0.29) харьцангуй бага өсөлттэй байна.
- Шинэлэг сэтгэлгээ: Эрэл хайгуул хийх чадвар (0.58), Асуудлыг шийдвэрлэх чадвар-2 (0.41) нь эмэгтэй сурагчдын шинэлэг сэтгэлгээ, эрэл хайгуул хийх үйл явцад тодорхой ахиц гарсныг илэрхийлж байна.

Чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нэмэлт хичээлийн үр дүнд эмэгтэй сурагчдын мэдлэг, чадварт ихээхэн өсөлт гарсан. Сурагчдын мэргэжлийн талаарх мэдлэг, өөрийгөө танин мэдэх, шийдвэр гаргах, төлөвлөх чадвар сайжирсан. Эмэгтэй сурагчдын сэтгэл зүйн төлөв байдал бага зэрэг ахисан ч, стрессээ удирдах чадварт илүү их анхаарал хандуулах шаардлагатай.

Статистикийн шинжилгээний дүнгээс үзэхэд мэдлэг болон үйлийн хэмжээс $p < .001$, $d > 0.7$ буюу өндөр ач холбогдолтой, хүчтэй нөлөөтэй өөрчлөлт гарсан бол сэдлийн хэмжээс $p = .04-.06$ хязгаарлагдмал, дунд зэргийн нөлөөтэй байв. Энэ нь сургалтын хөтөлбөрийн танин мэдэх ба практик хэрэглээний чиглэл илүү үр дүнтэй ч сэтгэл зүйн төлөв байдалд илүү дэмжлэг шаардлагатай болохыг харуулж байна.

Судалгааны үр дүн нь Ajzen (1991)-ийн Planned Behavior Theory-ийн “Хандлага-Хяналт-Сэдэл”-ийн уялдаа, Bandura (1997)-ийн Self-efficacy-ийн “өөртөө итгэх итгэл”, Driesel-Lange (2020)-ийн “Мэдлэг-Сэдэл-Үйл”-ийн гурван хэмжигдэхүүнт загварын бүтцийн логикийг нэгтгэн баталсан. Иймд уг судалгаа нь Монголын боловсрол дахь анхны туршилт бөгөөд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг сэдэл, үйлдэлтэй уялдуулсан онол-практикийн загвар болсноороо шинэлэг юм.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү судалгаа нь сурагчдын мэргэжил сонголтын чадамжийг үнэлэхэд чиглэсэн бөгөөд үр дүн нь тухайн чадамжийн түвшин, хөгжлийн шат, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлоход чиглэсэн. Энэ нь өмнөх судалгаануудтай харьцуулахад, сурагчдын чадамжийг мэдлэг-сэдэл-үйл гэсэн гурван хэмжээст харгалзах хүчин зүйлийн харилцан хамаарлыг нарийвчлан шинжилснээрээ онцлог байна. Судалгаанд А сургуулийн 196 сурагч хамрагдсан бөгөөд үр дүн нь тэдний мэргэжил сонголтын чадамж дээшилснийг харуулсан. Цаашид судалгааг хөгжүүлэхдээ асуумж, ажиглалт, туршилт зэрэг холимог арга зүй ашиглах нь чухал бөгөөд сурагчдын мэргэжил сонголтын чадамжийн хөгжил, өөрчлөлтийг урт хугацаанд хянах системийг боловсруулах шаардлагатай.

Судалгааны үр дүн нь нэгдүгээрт, сургалтын бодлого, ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх суурь мэдээлэл болж, мэргэжил сонголтод суурилсан чадамжийг тодорхойлох боломж олгоно. Хоёрдугаарт, чадамжид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох арга зүйн ур чадвар эзэмших бөгөөд гуравдугаарт, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгож, сурагчдын сэдэл, оролцоог дэмжих арга замыг тодорхойлоход бодит практик ач холбогдолтой.

Судалгааны үр дүнг ашиглан Мэдлэг-Сэдэл-Үйл гэсэн гурван хэмжигдэхүүнт загварт суурилсан жишиг хөтөлбөр, арга зүй, үнэлгээний загвар боловсруулах боломжтой. Энэ нь сурагчдын мэргэжил сонголтын чадамжийг шат дараатай хөгжүүлэх агуулга бүхий хичээлийг боловсруулах, идэвхтэй суралцах, мөн хичээлийн үр дүнг асуулга, ажиглалт, дадлагын үнэлгээгээр үнэлэх боломж бүрдүүлж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаа нь “Мэдлэг-Сэдэл-Үйл” гэсэн гурван хэмжигдэхүүнт загварыг ашиглан сурагчдын мэргэжил сонголтын чадамжид нөлөөлөх хүчин зүйлийг шинжилсэн. Судалгааны үр дүнд дараах зүй тогтол, онцлог ажиглагдлаа. Үүнд:

Мэдлэг → Сэдэл → Үйл гэсэн гинжин хэлхээний зүй тогтол илэрсэн. Мэдлэг, сэдэл, үйл гурвын хооронд маш өндөр хамааралтай ($r > .90$) байв. Мэдлэгийн өсөлт нь сэдэлд улмаар эерэг хандлага төлөвшихөд нөлөөлсөн. Энэ нь нэмэлт хичээлийн хөтөлбөр шат дараалалтай, уялдаа холбоотой байсныг харуулж байна.

Мэргэжил сонголтод хамгийн их нөлөөлөгч хүчин зүйл бол мэдлэг юм. Сурагчдын өөрийгөө танин мэдэх мэдлэг нь бусад чадварын суурь болж байгааг тогтоов. Өөртөө итгэх итгэл нь ажил мэргэжилтэй холбоотой мэдлэг, төлөвлөх мэдлэгтэй өндөр хамааралтай ($r = .714 - .773, p < .01$) бөгөөд төлөвлөх, шийдвэр гаргах хүчин зүйл чухал болохыг илтгэнэ.

Нэмэлт хичээлийн хэрэглэгдэхүүний (төлөвлөгч дэвтэр) үр нөлөө өндөр байв. Энэхүү гарын авлага нь сурагчдын урам зориг, өөртөө итгэх итгэл, оролцоонд эергээр нөлөөлж, бүтээлч байдалд ахиц авчирсан.

Сурагчдын өөрийн үнэлгээ болон бүтээлийн үнэлгээ уялдаатай байсан. Сурагчдын өөрийн үнэлгээ нь бүтээлийн үнэлгээтэй ойролцоо боловч хэт өөдрөгөөр үнэлэх хандлага ажиглагдсан. Жишээ нь, Стресс удирдах чадварын хувьд өөрийн үнэлгээ болон бүтээлийн үнэлгээний хоорондын зөрөө (-0.14) байна.

Хүйсийн ялгаа илэрхий ажиглагдсан. Эмэгтэй сурагчдын мэдлэг, төлөвлөлт, асуудал шийдвэрлэх чадвар, хандлага илүү ахицтай байв. Харин эрэгтэй сурагчдын өөрийгөө танин мэдэх мэдлэг, зорилго тодорхойлох, эрэл хайгуул хийх чадвар илүү ахицтай ч стрессээ удирдах чадвар, өөртөө итгэх итгэл сул байлаа.

Сэтгэл зүйн төлөв байдал хамгийн бага ахицтай байв. “Өөртөө итгэх итгэл”, “Стрессээ удирдах”, “Айдсаа даван туулах” гэх мэт сэтгэл зүйн төлөв байдал ахиц багатай, заримдаа буурсан байна.

Чадамжийн өсөлт жигд бус байв. Мэдлэг 22 хувь, чадвар 13 хувь, сэдэл 7 хувийн өсөлттэй байв. Судалгааны дүнгээс харахад сурагчдын мэргэжил сонголтын чадамжид мэдлэг хамгийн ихээр нөлөөлдөг ч сэтгэл зүйн төлөв байдлын хөгжил сул байгаагаас шалтгаалан нэмэлт хичээлийн хөтөлбөрийг мэдлэг, сэдэл, үйлийг бүх талаар тэнцвэртэй хөгжүүлж, шинэчлэх шаардлагатай байна.

ЗОХИОГЧДЫН ОРОЛЦОО

Зохиогчдын оролцоог *CRedit* таксономын дагуу тодорхойлсон. **Онолын үндэс:** Ц.Р., Л.А.; **Арга зүй:** Ц.Р., Л.А.; **Мэдээлэл цуглуулалт:** Ц.Р.; **Бичилт (эхний хувилбар):** Ц.Р., Л.А.; **Бичилт (хянах, засварлах):** Ц.Р., Л.А.; **Санхүүжилт:** Ц.Р.; **Нөөц, материалын дэмжлэг:** Ц.Р.; **Мэргэжлийн удирдлага:** Р.Б.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг

Монгол Улсын Үндсэн хууль. (1992). Улаанбаатар: Монгол Улсын Их Хурал.

Боловсролын ерөнхий хууль. (2023). Улаанбаатар: Монгол Улсын Их Хурал.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль. (2023). Улаанбаатар: Монгол Улсын Их Хурал.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль. (2023). Улаанбаатар: Монгол Улсын Их Хурал.

Хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаал А/165/А266. (2016). Улаанбаатар.

Судалгааны тайлан, статистикийн эмхэтгэл

Ажиллах хүчний судалгаа: I улирлын товч танилцуулга. (2022). Улаанбаатар: Үндэсний статистикийн хороо.

Монгол Улсын статистикийн эмхэтгэл. (2022). Улаанбаатар: Үндэсний статистикийн хороо.

Монгол улс дахь ур чадварын эрэлт: Барометрийн судалгааны Ур чадварын модулийн гол үр дүн, бодлогын зөвлөмж. (2022). Улаанбаатар: Үндэсний хөгжлийн газар.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа. (2022). Улаанбаатар: Үндэсний хөгжлийн газар.

Хөдөлмөрийн зах зээлийн тойм: I-р улирал. (2021). Улаанбаатар: Үндэсний статистикийн хороо.

Ном, сурах бичиг, гарын авлага

Байгалмаа, Ч. (2015). *Боловсролын судалгааны арга зүй*. Улаанбаатар: УБ.

Жадамба, Б., Батдэлгэр, Ж., Байгалмаа, Ч., & бусад. (2020). *Үйл судлал*. Улаанбаатар: УБ.

Кумар, Р. (2019). *Судалгааны арга зүй*. Улаанбаатар: УБ.

Колин, М., & Оюунаа, П. (2021). *Багшийн гарын авлага*. Улаанбаатар: УБ.

Rey, C., Bastons, M., & Sotok, P. (2019). *Purpose-driven organizations*. [Publisher if known].

Эрдэм шинжилгээний өгүүлэл

Klein, J., Driesel-Lange, K., & Ohlemann, S. (2022). Are adolescents in one-parent families a previously unnoticed group in inclusive career guidance? *Social Inclusion*, 10(2), 278–289. <https://doi.org/10.17645/si.v10i2.5085>

Судалгааны илтгэл, үнэлгээ

Мөнхцэцэг, Ш., Цэрэнжаргал, Г., & Хишигсайхан, Ж. (2019). *Ажил мэргэжлийн чиг баримжаа хөгжүүлэх бодлогын чиглэлийн дунд шатны хэрэгжилтийн үнэлгээ*. Улаанбаатар: Боловсролын хүрээлэн.

Судалгааны хэрэгсэл, баримт бичиг

Anhang B. *Skalendokumentation zum Fragebogen Berufswahlkompetenz*. (n.d.).

Зохиогчдын мэдээлэл

Овог, нэр: Цэдэнжавын Рэгэнбазар
 <https://orcid.org/0009-0008-5360-7208>
 Байгууллагын нэр: МУБИС
 Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө, МУБИС-ийн хичээлийн IX байр, 503 тоот
 Улс: Монгол
 e-mail: regzenbazartsedenjav@gmail.com

Овог, нэр: Лхагва.Ариунжаргал
 <https://orcid.org/0009-0007-5590-2721>
 Байгууллагын нэр: МУБИС
 Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө, МУБИС-ийн хичээлийн IX байр, 503 тоот
 Улс: Монгол
 e-mail: mubisariunjargal@msue.edu.mn
